

## ХЯТАД, МОНГОЛЫН ХИЛИЙН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БҮС БАЙГУУЛАХ ТУХАЙД

*Баатар\**

Чөлөөт худалдааны бүс бол эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааны нэгэн төрөл юм. Чөлөөт эдийн засгийн бүсийн анхны үүслийг мөшгөвөл, 1547 онд Италийн Генуя-гийн чөлөөт боомтоос эхтэй бөгөөд эдүгээ нэгэнт 400 гаруй жилийн түүхтэй болжээ. Эдийн засгийн чөлөөт бүс нь Засгийн газраас сонгосон, газар зүйн байрлал сайтай газарт, худалдааны саад тотгорыг арилгах, гаалийн татвараас чөлөөлөх, холбогдох бусад хөнгөлөлт эдлүүлэх зэрэг бодлого хэрэгжүүлдэг. Түүнийг байгуулах зорилт адилгүйн улмаас үйлдвэрлэлийн бүтэц, үйл ажиллагааны төрөл хэлбэр нь ч адилгүй.

Эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн үйл явцыг ажиглавал, түүнийг үндсэнд нь 4 төрөлд хувааж болно. Үүнд: чөлөөт боомт, чөлөөт худалдааны бүс, экспортын бүтээгдэхүүн боловсруулах бүс, шинжлэх ухаан-технологийн үйлдвэрлэлийн бүс болно.

Эдийн засгийн чөлөөт бүс нь одоогоор орон зайн хувьд, хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнууд руу хандан түргэн хурдацтай өргөжиж байна. Цаг хугацааны хувьд, геометрийн хурдлаар өсч байна. /Дэлхийн эдийн засгийн чөлөөт бүсийн нийт тоо 1000 гаруй болоод байна/

Чөлөөт худалдааны бүсийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүтэц, татварын хөнгөлөлтийн талаас нь авч үзвэл, гол нь худалдааг, дараа нь үйлдвэрлэлийг нээлттэй болгож, гадаадын бараа бүтээгдэхүүний бүгдийг буюу дийлэнхийг экспорт, импортын гаалийн татвараас чөлөөлөх; улсын дотоод гадаадын хөрөнгө оруулалтаар боловсруулах үйлдвэр байгуулах, гадаадын хөрөнгө оруулагчдад худалдаа, санхүү, жуулчлал эрхлэхийг зөвшөөрдөг. Хэдийгээр чөлөөт худалдааны бүс нь одоогоор гол төлөв хөгжингүй улсуудад байгаа ч эдийн засгийн даяаршил, зах зээлийн хөгжлийг дагалдаад хөгжиж буй олон улс орон энэхүү эдийн засгийн арга хэлбэрийг ашиглах нь улам бүр нэмэгдэж, сайн үр дүнд хүрч байна. Ялангуяа түүний сайн талыг олж харсан зарим улс орон, зах зээл болон улс орныхоо ашигт малтмалыг тэнцвэртэй нээн ашиглах давхар зорилт дэвшүүлэн, түүнийгээ хилийн дагуу хэрэгжүүлж ихээхэн үр дүнд хүрч байгаа юм.

\*Баатар- ӨМӨЗО-ы Зүүн Хойт Ази судлалын хүрээлэнгийн судлаач, дэд профессор

Эдүгээ үндэслэл гаргах буюу бэлтгэлийн шатандаа яваа Хятад, Монголын хилийн бүсэд аль нэг хэлбэрийн чөлөөт эдийн засгийн бүс байгуулахыг Хятадын тал үндэслэл гаргах шатанд байна гэж үзэхийн зэрэгцээ чөлөөт худалдааны бүс гэж нэрлэх саналтай бол Монголын тал түүнийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгаж, эдийн засгийн чөлөөт бүс гэж нэрлэн, байгуулах бэлтгэлийн шатандаа ороод байна.

Үүнийг бичигч миний бие бодоход:

1. Хятад, Монгол хоёр улс нь 4600 гаруй км хамтын хилийн шугамтай. Энэ нь хятадын эх газрын хилийн шугамын бараг 20%-ийг, Монголын хилийн шугамын ихэнхи хагасыг эзлэх бөгөөд аль аль нь нөгөө талынхаа хамгийн урт, хамтын хилийн шугамтай улс болдог.

2. Газар зүй, иргэншилд тулгуурласан эдийн засгийн хамтын ажиллагаа, харилцан түшиглэлийн нэн сайн харилцаатай. Тухайлбал, 1999 онд Хятад-Монголын худалдааны хэмжээ 261 сая 730 мянган америк долларт хүрч, Хятад улс Монголын гадаад худалдааны нэгдүгээр түнш болов. Мөн онд Монгол Улс нь ӨМӨЗО –ы экспортын гуравдагч орон болов. 1999 оны эцсээр, Хятадын Монголд бүртгэгдсэн шууд хөрөнгө оруулалт 68 сая 514 мянган ам. долларт хүрч, Монгол дахь гадаадын нийт хөрөнгө оруулалтын 23,4%-ийг эзэлж, Монголд хамгийн том хөрөнгө оруулагч улс болов; Жуулчлал, барилга хөдөлмөрийн хамтын ажиллагаа, техник төхөөрөмж нийлүүлэлт, зам тээвэр хийгээд эдийн засгийн тусламж зэрэг талын хамтын ажиллагаа илүү үр дүнд хүрч, 2,4 сая гаруй хүн амтай Монгол Улс 2002 онд Хятадад жуулчилсан хүнийхээ тоогоор эхний 10 улсын тоонд багтав.

3. Хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаа харилцан түшиглэл нь бат бэх эдийн засгийн харилцан нөхөх үндэс суурьтай юм.

4. Хоёр талын харилцах гарц 1956 онд Эрээний боомт нээсэнээр тавигдаж эдүгээ Хятад Монголын хилийн шугамын дагуу хоёр талдаа 9 боомттой болсоноос эрээн хот бүтэн жилийн турш нээлттэй цорын ганц төмөр замын боомт юм. Түүнчлэн Эрээн нь Хятад, Монголын бараа таваар, зорчигчдын орж, гарах гол газар төдийгүй Хятадаас Орос, Европын улсуудад хүрэх эх газрын чухал зангилаа ертөө бөгөөд газар зүйн байршил дэд бүтэц, суурь хотын дэмжлэг, хэрэглээний зах зээл, хямд ажиллах хүчний талаар чөлөөт худалдааны бүс байгуулах үндсэн нөхцөл сайн юм.

5. Төрийн бодлого болон Эрээний нөхцөл бололцоо нь чөлөөт худалдааны бүс байгуулж хөгжүүлэх хоёр гол хүчин зүйл бөгөөд алдаж болшгүй сайхан боломж бүрдээд байна. Хятадын Засгийн газраас эх газрын хил, хилийн шугам, далайн эргийг нээлттэй болгосноос хойш, олон салбараар бүх шатанд, бүх талаар нээлттэй бодлогыг үргэлжлүүлэн явуулж, “баруун бүс нутгийг ихээр нээж хөгжүүлэх” стратеги дэвшүүлээд байна. Монголын Засгийн газар Хятадыг хамааран Зүүн Азийн улсуудын эдийн засгийн түшиглэх бодлого хэрэгжүүлж байна.

6. Гадаад орчныг ашиглахад, эдийн засгийн даяаршил, зах зээл, мэдээлэл улам түргэсэж, буурай улс орон, бүс нутгийн өмнө урагшлахгүй бол ухрах зам тулгарч буй тул Эрээний орчимд чөлөөт худалдааны бүс байгуулах нь дээр дурдсан үндсэн нөхцөл, төрийн бодлого, хөгжлийн хандлагад нийцсэн, зайлшгүй чухал стратегийн арга хэмжээ болох юм. Түүнчилэн хилийн боомтын нийцэх чанар, зах зээлийн нэг талт байдал, эд баялагийн хүчин зүйлийг ашиглах зэргийг зүй зохистой харгалзаж, хоёр улс хэлэлцэн тогтож, нэгэн адил цаг хугацаанд, хил дамнасан чөлөөт худалдааны бүс байгуулах нь илүү үр дүнтэй бөгөөд үр дүн нь хоёр талын хамтын ажиллагаанаас шалтгаална гэж үзэж байна. Үүнд:

1. Хил дамнасан, нэн өргөн хүрээнд эд баялагийн хамгийн сайн байршлыг бий болгож, Хятад, Монголын хилийн дагуух эдийн засаг, улмаар нийт эдийн засгийн хамтын ажиллагааны цар хүрээг дээшлүүлэх явдал юм.

Чөлөөт худалдааны бүс байгуулах нь гаалийн татваргүй болгох, зарим нэг саад бэрхшээлийг арилгах, улмаар эдийн засгийн хөрөнгө баялагийг чөлөөтэй солилцох явдлыг ахиулахаас гадна түүгээр төвлөрсөн, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээнд зохицсон хамгийн их ашиг орлоготой зарчимд тулгуурласан төв байх юм. Энэ нь чөлөөт худалдааны бүсийн дотоод эдийн засгийн хууль журамд ч нийцнэ. Дээр дурдсанаар, хэдийгээр Хятад, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа тодорхой үндэс суурьтай ч хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцэхэд нилээд зайтай байна. Өнөөгийн хилийн эдийн засаг техникийн хамтын ажиллагаанаас харахад, зөвхөн хилийн худалдаа, хилийн барилга, байгууламж барих гэрээ, хөдөлмөрийн гэрээ, хилийн жуулчлал зэргээр хязгаарлагдаж байгаа нь хоёр орны хооронд хөрөнгө, техник хөдөлмөрийн хүч, зах зээл, ашигт малтмал,

үйлдвэрлэлийн бүтцийн өсөлтийн талаар асар их нөхвөрлөх байдлыг гүйцэд ашиглаж чадахгүй байна.

Хилийн худалдаа 1985 онд сэргэснээс хойш хилийн эдийн засгийн сэргэлт хийгээд бүхэлдээ хоёр орны таваарын худалдаанд маш том хувь нэмэр оруулсан хэдий ч эцсийн эцэст тодорхой түүхэн цаг хугацааны бүтээгдэхүүн, мөн таваарын худалдааны далд зэрэглэлийн хэлбэр төдий бөгөөд зөвхөн худалдааны хөрөнгийн эргэлтийн анхан шатанд зохицохыг түрүүчийн жилүүдэд Хятад, Монголын худалдаанд гарч байсан өсөлт бууралт ч үүнийг нотолсон юм. Эдийн засгийн өсөлтийн өөрийнх нь хуулиас үзэхэд, худалдааны капитал нь үйлдвэрлэл ба санхүүгийн капитал болон хувирч, улмаар зохицон хөгжиж байж сая эдийн засгийн агуулга, зэрэглэлийг дээшлүүлэх шаардлагыг хангаж чадах ба хоёр орны хоорондох эдийн засгийн хамтын ажиллагаа ч үүнээс ангид биш юм. Өөрөөр хэлбэл, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны түвшинг дээшлүүлэхэд хууль эрхийн дэмжлэг шаардлагатай ба чөлөөт худалдааны бүс байгуулах нь даруй нэн сайн хууль эрхийн дэмжлэгтэй, тэр нь баталгаатай байх хэрэгтэй юм.

2. Хоёр талын экспортыг нэмэгдүүлэн, аль аль талын дутагдалтай хөрөнгө, техник, аж ахуй эрхлэх туршлагаа хуримтлуулна. Олон улсын худалдааг эдийн засгийн хөгжлийн хөдөлгөгч хүч гэдэг бөгөөд энэ хүчний гол цөм технологи нь хэрхэн түүнийг нэмэгдүүлэх вэ гэдэгт байх учиртай, хөрөнгө, техникийн хомсдолтой хөгжиж буй улс, экспортыг их хэмжээгээр нэмэгдүүлэх нь хомсдолтой эд баялагаа хуримтлуулах үр ашигтай арга зам болох ба зах зээлийн багтаамж бага улсын тухайд ч ийм юм. Эрээнд байгуулах бүсийн анхны санаа бол гадаадын хөрөнгө татаж, хөрөнгө техникийг хуримтлуулах явдал, худалдааг нээлттэй болгож, улмаар бүхэлд нь нээлттэй байлгаж эргэн тойрны бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд оршино. Энэ нь олон улсын хөрөнгө татаж чадах эсэхийн чухал шалгуур болно.

Дээр дурдсанчилан, Эрээн хот нь олон улсын худалдаа явуулах газар зүй, зам тээврийн зэрэг нөхцөлтэй. Хэрэв уян хатан, хөнгөлөлттэй бодлогын дэмжлэг олж чадвал, өнөө байгуулах гэж буй бүс нь олон улсын ба дотоодын хөрөнгө, техникийг татах болно. Өнгөрсөн зууны 60-70-аад оны үеийн БНСУ, Тайвань, Мексик зэрэг орон, бүс нутагт байгуулсан экспортын боловсруулах бүсийн /Мексикт “хилийн зочин үйлдвэрлэлийн бүс” гэдэг/ тоо бүртгэлээс үзэхэд, нэг бүсийн жил бүр өсөж буй экспортын хэмжээ 100 сая америк долларт хүрч байв.

Хэдийгээр Эрээний бүсийн одоогийн зах зээлийн объект болох Монгол Улс, Оросын Буриадын зах зээлийн багтаамж нэн бага боловч хилийн болон транзит худалдаа хийж, бүсийн дотоодод үйлдвэрлэсэн зарим бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд болон Зүүн Хойт Азийн бүс нутгийн зах зээлд борлуулах уян хатан бодлогыг баримтлах нь экспортын урагшлуулагч үүрэгтэйг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн энэ үүрэг ойрын ирээдүйд нэмэгдэнэ гэдгийг урьдчилан хэлж болно. Монголын талын төлөвлөж буй Замын-Үүдэд байгуулах чөлөөт эдийн засгийн бүсийг зах зээлийн нөхцөлийг авч үзвэл Хятадын талаас ч илүү юм.

3. Хоёр талын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц өгч, ялангуяа Хятадаас Монголд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. Хилийн чөлөөт худалдааны бүсийн тохиромжтой байдал, зах зээлийн дан гагц байдлын улмаас түүнийг зохион байгуулахдаа хоёр талын нөхцөлд нийцсэн, арга хэмжээг сайтар авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Хоёр тал зөвлөлдөн тохиролцсоны үндсэн дээр бүрэлдэн бий болж буй хууль дүрмийн шинэлэг, нэгдсэн хүчийг ашиглан хөгжингүй улсын хөрөнгө техникийг татан авч чадахаар үл барам газар зүй, хүмүүнлэгийн давуу талд түшиглэн тус бүрийн дотоодын үйлдвэрлэл, худалдааны хөрөнгө, технологийг татаж чадна. Учир нь:

1. Энд чөлөөт худалдааны бүс байгуулах нь бодлогын болоод газар орны давуу талтай.

2. Чөлөөт худалдааны бүсийг амжилттай сайн ажиллуулахыг тулд хоёр талын хэрэгжүүлж буй хууль эрхийн шинэ нэгдмэл хүч байгаа.

3. Энд тогтолцоо, механизмын талаар зөрөө, зангилаа асуудал байхгүй.

4. Хилийн районы эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахын тулд хоёр тал хамтын ажиллагааны эдийн засгийн бүхий л орчинг сайжруулна. Хилийн чөлөөт худалдааны бүс байгуулах нь хөрөнгө, технологи, мэдээлэл, бараа таваарыг бөөгнөрүүлэн төвлөрүүлэн, үйлдвэрлэлийн бүтцийг дээшлүүлэх замаар хилийн районы эдийн засгийн өсөлтийг бий болгоно. Энэхүү өсөлт нь дагуулах, төвлөрөх үүргээр дамжин, хилийн районы үйлдвэрлэлийн бүтцийг дээшлүүлэхийн зэрэгцээ, дэд бүтцийг хамарсан хоёр талын бүхий л хамтын ажиллагааны эдийн засгийн орчинг сайжруулна.

5. Хил худалдааны чөлөөт бүс нь бүс нутгийн интеграцчиллийг гүнзгийрүүлж хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны орон зайг тэлнэ. Чөлөөт худалдааны бүсийн ойлголтоор, тэр нь худалдааны саад

тотторыг арилгах, гаалийн татвараас чөлөөлөх, янз бүрийн хөнгөлөлт үзүүлэх явдлыг үндсэн үйл ажиллагаа болгосон бүс нутаг юм. Энэ үүднээс чөлөөт бүс нь бүс нутгийн интеграцчилалтай төстэй бөгөөд интеграцчиллийн орны нутгийн бичил тусгал гэж болно.

Нэрт эрдэмтэн Бейл Паллас бүс нутгийн интеграцчиллийн явцыг 1. чөлөөт худалдааны их бүс. 2. гаалийн татварын холбоо. 3. нийтийн зах зээл. 4. эдийн засгийн холбоо. 5. иж бүрэн эдийн засгийн интеграцчилал гэж 5 үе шатанд хуваажээ. Түүний үзэж байгаагаар, одоогийн “Европын Холбоо” нь эдийн засгийн холбооны шатанд байгаа ба хөгжиж буй олон орны хоорондын бүс нутгийн интеграцчилал олон төрлийн шалтгааны улмаас бүрэн гүйцэд биш, ердөө л 1-р шат буюу 1-р шатны эхэн үед явж байна.

Зүүн Хойт Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа ч 1-р шатны эхэн үед байна гэж бид үзэж байна. Олонд тодорхой шалтгааны улмаас ЗХА-ийн бүс нутаг нь бүс нутгийн интеграци зохион байгуулалтаас ангид буй цөөхөн бүс нутгийн нэг бөгөөд дөнгөж эхэлж буй бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа ч хязгаартай байгаа билээ. Ийм байдал нь дэлхийн эдийн засгийн интеграцчилал ба бүс нутгийн интеграцчилал түргэн хурдацтай хөгжиж байгаа өнөө үед, бүс нутгийн доторхи улс орнуудад нэн ашиггүй юм.

*Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав*